



Аудитын код: САГ-2018/6/СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Жавхлан
Утас: 261628 Цахим хаяг: javkhlang@audit.gov.mn

Улаанбаатар хот




Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.5	Дотоод хяналт.....	6
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.7	Шилэн дансны мэдээлэл	7
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
2.9.1	Санхүүгийн тайлагнал.....	7
2.9.2	Нэр, данс зөрүүтэй гүйлгээний талаар.....	7
2.9.3	Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлын талаар	7
2.9.4	Өр төлбөрийн талаар	7
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	8
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	8
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
2.16	Аудитаар тооцсон үр өгөөж.....	8
3	Менежментийн захидал	9
3.1	өр төлбөрийн талаар.....	10
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	11
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	11
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн НЭГТГЭСЭН үр дүнгийн тайлан	12
4.2.1	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15



1 Аудитын гэрчилгээ

 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг Бага тойруу-3, Засгийн газрын IV байр Утас:26-04-37, Факс:62-26-32-30 E-mail: info@audit.gov.mn	<p>ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Б.НЯМДАВАА ТАНАА</p>
<p>2017.03.23 № 06/822 танай _____-ны № _____-т</p>	
<p>Аудитын гэрчилгээ</p>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
<p>Зөрчилгүй санал дүгнэлт</p>	
<p>Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
<p>Санал дүгнэлтийн үндэслэл</p>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	
<p>\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0323SAG43.Docx</p> <p>071489</p>	



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ц.Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ



\\10.10.10.201\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0323SAG43.Docx



2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Б.Нямдаваа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай сангийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.


Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 03 дугаар сарын 5-наас 2018 оны 03 дугаар сарын 23-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, тус сангийн төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан хэрэгжүүлэв.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас Төсвийн тухай хуулийн хугацаанд багтааж 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 89/1 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИЛТ

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох



бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/ зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тус сан нь 40 Мэргэжил, сургалтын төвүүдийн хувьсах зардлыг санхүүжүүлэн, Мэргэжлийн сургалт, боловсролын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангуулан ажилладаг Засгийн газрын тусгай сан юм.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 2 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 8 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн нягтлан бодогч санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Финанс” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалттай хэмжээнд хэрэгжиж байна гэж үзлээ.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан 2017 оны төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангаар 8,954.5 сая төгрөгийн батлагдсан нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгээс 8,125.3 сая төгрөг зарцуулж, гүйцэтгэл 90.7 хувьтай тайлагнасан байна.

Зарцуулагдаагүй үлдсэн санхүүжилтийн 829.2 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт буцааж төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.



2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад тус сан хуулийн дагуу мэдээллүүдийг шилэн дансанд бүрэн мэдээлж ажилласан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 2 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Санхүүгийн тайлагнал

Хуримтлагдсан үр дүнгийн өмнөх оны үр дүн 2,143.5 сая төгрөгийг цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тусгагдаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

2.9.2 Нэр, данс зөрүүтэй гүйлгээний талаар

Тайлант онд нэр данс зөрүүтэй 64.7 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэр дансны зөрүүтэй гүйлгээг аудитын явцад залруулав.

2.9.3 Хичээл, үйлдвэрлэлийн дадлагын зардлын талаар

ХХҮЕГ-ын даргын 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/234 дүгээр тушаалаар хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж Улсын драмын эрдмийн театрын танхимын түрээсэнд 0.7 сая төгрөг, хоолны зардалд 8.5 сая төгрөг, хулдаасан хэвлэлд 0.2 сая төгрөг, урилга хэвлүүлэхэд 0.2 сая төгрөг, нийт 9.6 сая төгрөгийн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан ...хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг арилгуулах, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

2.9.4 Өр төлбөрийн талаар

МБСДС-гийн 2016 онд үүссэн 2,143.5 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулахаар 2017 оны төсөвт 1,968.8 сая төгрөгийг төсөвлөсөн ба зөрүү 174.7 сая төгрөгийг суралцагчдын хувьсах зардлаас төлсөн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх;

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.



2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй байна.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт нийт 2,392.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 9.6 сая төгрөгийн 1 зөрчил арилгуулах албан шаардлага өгч, 174.7 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгч, 2,208.2 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж ажиллав.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Мэргэжлийн боловсрол, сургалтын сангийн 2016 жилийн эцсийн санхүүгийн тайланг Үндэсний аудитын газраас баталгаажуулж, 3 албан шаардлага, 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн 6,864.9 сая төгрөгийн нийт зардлын 2 хувиар буюу 137.2 сая төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь, түвшин өөрчлөгдөөгүй болно.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар 137.2 сая төгрөгийн материаллаг байдлын түвшинг тогтоосон бөгөөд илэрсэн нийт материаллаг алдаа нь 9.6 сая төгрөг буюу материаллаг байдлын түвшингөөс даваагүй болно.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

2.16 АУДИТААР ТООЦСОН ҮР ӨГӨӨЖ

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан нь тайлант онд 16577 суралцагчаар төлөвлөгөөгөө батлуулсан боловч гүйцэтгэлээр 10036 суралцагч суралцсан байна. Цаашид төсвийг бодитой төлөвлөснөөр улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй байх, төсвийн зарцуулалтад эерэг нөлөө үзүүлнэ гэж тооцов.

Тус сан Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж төсвийг бодитой төлөвлөж хэвшсэнээр улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй байх, сангийн орлого зарцуулалт оновчтой болох зэргээр 500.0 хүртэлх төгрөгийн үр өгөөж бий болж чанарын томоохон ахиц дэвшил бий болно гэж урьдчилан төлөвлөв.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 ӨР ТӨЛБӨРИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

МБСДС-гийн 2016 онд үүссэн 2,143.5 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулахаар 2017 оны төсөвт 1,968.8 сая төгрөгийг төсөвлөсөн ба зөрүү 174.7 сая төгрөгийг суралцагчдын хувьсах зардлаас төлсөн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", Төсвийн тухай хуулийн 16 дугаар 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Төсвийг бодитой бус төлөвлөснөөр зарцуулалтын үр ашиг буурах;

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах, Төсвийг бодитой төлөвлөж хэвших

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлтүүд	/мянган төгрөгөөр/	
		Оны эхний үлдэгдэл	Оны эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.0	0.0
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0.0	0.0
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.0	0.0
3121	Төгрөг	0.0	0.0
31213	Арилжааны банкин дахь харилцах	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	0.0	0.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,143,551.7	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,143,551.7	0.0
413	Өглөг	2,143,551.7	0.0
4136	Бусад өглөг	2,143,551.7	0.0
41361	Байгууллагад төлөх өглөг	2,143,551.7	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	-2,143,551.7	0.0
51	Засгийн газрын хувь оролцоо	-2,143,551.7	0.0
512	Хуримтлагдсан үр дүн	-2,143,551.7	0.0
51210	Өмнөх үеийн үр дүн	-2,143,551.7	-2,143,551.7
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	2,143,551.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	0.0	0.0



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлтүүд	/мянган төгрөгөөр/	
		Оны эхний үлдэгдэл	Оны эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	15,611,030.5	9,008,541.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,149,310.8	54,020.0
120	Нийтлэг татварын бус орлого	10,149,310.8	54,020.0
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	10,149,310.8	0.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,149,310.8	0.0
120009	Бусад орлого	0.0	54,020.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,461,719.7	8,954,521.6
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,461,719.7	8,954,521.6
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,461,719.7	8,954,521.6
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	9,571,748.2	6,864,989.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,369,638.9	5,981,731.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,369,638.9	5,981,731.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	217,500.0	0.0
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	217,500.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,152,138.9	5,981,731.5
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	6,152,138.9	5,981,731.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,202,109.3	883,258.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,141,985.6	0.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,141,985.6	0.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	60,123.7	883,258.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	60,123.7	883,258.3
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	6,039,282.3	2,143,551.7
7	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	6,039,282.3	2,143,551.7



4.2.1 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			-8,182,834.0	-8,182,834.0
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			-8,182,834.0	-8,182,834.0
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
C07	Тайлант үеийн үр дүн			6,039,282.3	6,039,282.3
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			-2,143,551.7	-2,143,551.7
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			-2,143,551.7	-2,143,551.7
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
D08	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			2,143,551.7	2,143,551.7
D09	Тайлант үеийн үр дүн				



4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	15,646,620.4	9,008,541.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,184,900.7	54,020.0
120	Нийтлэг татварын бус орлого	10,184,900.7	54,020.0
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	10,149,310.8	0.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,149,310.8	0.0
120009	Бусад орлого	35,589.9	54,020.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,461,719.7	8,954,521.6
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,461,719.7	8,954,521.6
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,461,719.7	8,954,521.6
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	15,646,620.4	9,008,541.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,646,620.4	9,008,541.6
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,444,936.0	8,125,283.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,500.0	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	67,500.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,377,436.0	8,125,283.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	5,377,436.0	8,125,283.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,201,684.4	883,258.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,141,560.7	0.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	10,141,560.7	0.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	60,123.7	883,258.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	60,123.7	883,258.3
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.0	0.0
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0



4.4 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Тайлан оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0	(0.0)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,954,521.6	8,125,283.3	829,238.3	90.74
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	8,954,521.6	8,125,283.3	829,238.3	90.74
210	Бараа, үйлчилгээний зардал	8,954,521.6	8,125,283.3	829,238.3	90.74
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	8,954,521.6	8,125,283.3	829,238.3	90.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,954,521.6	8,125,283.3	829,238.3	90.74
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,954,521.6	8,125,283.3	829,238.3	90.74
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,954,521.6	8,125,283.3	829,238.3	90.74
131001	Улсын төсвөөс санхүүжих	8,954,521.6	8,125,283.3	829,238.3	90.74
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	0.0	0.0	0.0	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0	(0.0)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0	(0.0)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0.0	0.0	0.0	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.0	0.0	0.0	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	0.0	0.0	0.0	-
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	16,577.00	10,036.00	6,541.00	60.54
632	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв	16,577.00	10,036.00	6,541.00	60.54
632002	Хувийн МСҮТ	16,577.00	10,036.00	6,541.00	60.54

